



СЕКЮРИТИЗ  
ҮЦК

2022.06.06-2022.06.10

# ГАДААД ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ





2022.06.13-ны pre-trading session байдлаар

АНУ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
US30	30,782.00	-1.92%	-6.53%	-4.52%	-10.54%
US500	3,810.95	-2.25%	-7.68%	-5.07%	-10.58%
NASDAQ	11,500.00	-2.79%	-6.09%	-3.35%	-16.25%
Европ	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
GB100	7,208.00	-1.50%	-5.36%	-3.54%	0.75%
DE40	13,506.00	-1.79%	-7.99%	-3.45%	-13.48%
FR40	6,060.00	-2.07%	-7.77%	-4.85%	-8.71%
IT40	22,129.00	-1.85%	-10.18%	-8.19%	-14.34%
ES35	8,250.00	-1.69%	-6.85%	-1.47%	-11.31%
Ази	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
JP225	26,987.00	-3.01%	-3.33%	1.66%	-7.46%
SHANGHAI	3,256.00	-0.89%	0.59%	5.91%	-8.46%
CSI 300	4,189.00	-1.17%	0.56%	5.88%	-18.91%
SHANGHAI 50	2,845.00	-1.89%	0.68%	4.57%	-19.38%
CH50	13,798.50	-2.14%	0.48%	4.86%	-21.83%
SENSEX	52,594.00	-3.14%	-5.46%	-0.64%	0.16%
Эрчим хүч	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Газрын тос (Crude)	118.55	-1.80%	0.04%	6.02%	67.85%
Газрын тос (Brent)	120.00	-1.70%	0.45%	7.08%	64.77%
Байгалийн хий	8.65	-2.32%	-7.21%	8.72%	158.05%
Шатахуун	4.06	-2.58%	-2.80%	6.12%	87.72%
Нүүрс	392.35	-0.92%	-4.88%	1.91%	208.94%
Түүхий эд	Ханш	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
Алт	1,853.51	-0.93%	0.73%	1.68%	-0.62%
Мөнгө	21.45	-1.91%	-2.64%	-0.59%	-22.86%
Зэс	4.20	-2.24%	-5.27%	0.37%	-7.10%
Бонд /10 жил/	Өгөөж	Өөрчлөлт	7 хоног	1 Сар	1 жил
АНУ	3.23	0.0677	0.19%	0.35%	1.73%
Англи	2.48	0.0380	0.23%	0.75%	1.74%
Швейцар	1.19	0.0440	0.17%	0.43%	1.42%
Испани	2.86	0.0950	0.39%	0.86%	2.46%
Португали	2.90	0.1070	0.37%	0.84%	2.52%

## Өнгөрсөн 7 хоногийн онцлох мэдээ яах аргагүй АНУ-ын 5 сарын инфляцын түвшинтэй холбоотой байлаа

Өнгөрсөн Баасан гарагт АНУ-ын энгийн хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 8.6% хүрсэн мэдээ нь таамаглаж байсан 8.2%-аас харьцангуй өндөр гарсан бол гол ХҮИ (эрчим хүч, хүнсний үнийн өсөлт ороогүй) 6% гарсан нь 5.9%-иас давсан үзүүлэлттэй гарчээ. Эдгээр мэдээнүүдээс болж хөрөнгийн зах зээл 5%-иар унасан нь цаашдын өсөлтөд сөргөөр нөлөөлөхөөр байна.

### Энгийн ХҮИ болон гол ХҮИ хоёрын зөрүү ихсэж байна

Сүүлийн хэдэн сард эрчим хүч болоод хоол хүнсний үнийн өсөлтийг багтаасан энгийн ХҮИ гол ХҮИ-ээс илүү хурдтай өсөж байгаа нь тод харагдаж байна. 5 сард энэхүү хоёр ХҮИ-ийн зөрүү хамгийн их гарсан.

АНУ-ын ХҮИ



Эх сурвалж: Fred.com



## Энгийн ХҮИ-ийг юу хамгийн их өсгөж байна вэ?

Энгийн ХҮИ-ийг гол өсгөж байгаа хүчин зүйлс бол яах аргагүй олон улсад ажиглагдаж буй эрчим хүч болоод хоол хүнсний үнийн өсөлт байна. Орос-Украины дайн, БНХАУ-ын хөл хорионы дараах сэргэж буй эрэлтээс үүдэж түүхий эдийн ханш дараагийн хэдэн сард өсөх хандлагатай байна. Газрын тосны ханш гэхэд 5 сард ойролцоогоор 9% өссөн бол 6 сар гарснаар 7% өссөн байгаа нь 120 доллар хүргээд байна.

Газрын тос, түүхий эдийн ханш




ХНС бодлогын хүүг өсгөж хоол хүнсний эрэлтийг буулгах аргаар инфляцын өсөлтийг сааруулах гэж оролдож магадгүй боловч олон улсын түүхий эдийн ханшийн хөдөлгөөнд дорвитой нөлөөлж чадахгүй.

## Инфляцын түвшин ирээдүйд унах боломж бий юу?

5 сарын ХҮИ-ийн мэдээнээс ганц авууштай зүйл нь гол ХҮИ 6.2%-ийн өсөлтөөс саарч 6% болсон явдал байлаа. Гол нөлөөлсөн хүчин зүйлс нь эрүүл мэнд болон тээврийн үйлчилгээний үнэ буурсантай холбоотой байв. Сүүлийн үед орон сууцны зээлийн хүү ихээхэн өсөж байгаа нь байрны үнийн өсөлтийг буурахад нөлөөлж болно. Мөн технологийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниуд ажилчдаа халж эхэлсэн нь цалингийн өсөлтийг сааруулж инфляцыг бууруулж болох юм.

ХНС бодлогын хүүг хэдэн хувиар өсгөх магадлал



## Инфляц ийнхүү өсөж байгаа нь ХНСанг ямар үйлдэл хийхийг харах үлдлээ

ХНС-аас 6 болон 7 сард бодлогын хүүг 0.5%-иар өсгөхөө мэдэгдсэн билээ. Өнгөрсөн 7 хоногийн мэдээгээр инфляц өсөлттэй гарсан тул 9 сард нэмж 0.5%-иар өсгөх магадлал өндөр болж байна. Шинжээчдийн үзэж байгаагаар бодлогын хүүг 0.5%-иар өсгөх магадлалыг 62%-тай таамаглаж байгаа бол илүү чангаар буюу 0.75%-иар өсгөх боломж 33%-тай байна гэжээ.



## Эдийн засгийн хямрал болох нь ойлгомжтой болсон уу?

Хэдий S&P 500 индекс он гарснаас хойш 18% унаж, Nasdaq индекс 27% унаж, шинжээчид ирэх 12 сарын хугацаанд эдийн засгийн хямрал болох магадлалыг 70%-тай таамагласан ч Edward Jones-ийн шинжээчид хямрал болно гэж харахгүй байна. Тэдний үзэж байгаагаар АНУ-ын эдийн засаг харьцангуй тогтвортой байгаа гэж харж байна.

Жишээлбэл өрхийн худалдан авалт, хөдөлмөрийн зах зээл болон компаниудын ашигт ажиллагаа сайн байгаа гэж үзжээ. Эдгээр нь төв банкнаас хатуу мөнгөний бодлого баримталж байгаа үед дэмжлэг үзүүлнэ гэжээ. ХНС бодлогын хүүг нэмэгдүүлснээр олон улсын түүхий эдийн зах зээлд нөлөөлөх боломжгүйг мэдэж байгаа тул яарч сандарч биш судалгаа шинжилгээ нь дээр үндэслэж шийдвэр гаргана гэдэгт найдаж байна.